# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 8 (341)

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:**

- *Гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай*

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:**

- *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай*
- *Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож мөрдүүлэх тухай*
- *"Төрийн мэдээлэл" эмхтгэлийг захиалж байх тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2004 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны хоёрдугаар сарын 27 № 8 (341)


## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 87. | Цэрэнгийн Дагданд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 199 | 126 |
| 88. | Чойгивын Сангидоржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 200 | 126 |
| 89. | Очирбатын Ичинхорлоод Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 201 | 126 |
| 90. | Хорлоогийн Далантайд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 202 | 127 |
| 91. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 203 | 127 |
| 92. | Зарим хүнийг "Шударга журам" медалиар шагнах тухай | Дугаар 204 | 131 |
| 93. | Зарим уяачдад улсын тод манлай уяач цол олгох тухай | Дугаар 205 | 131 |
| 94. | Зарим уяачдад улсын манлай уяач цол олгох тухай | Дугаар 206 | 132 |
| 95. | Зарим уяачдад улсын алдарт уяач цол олгох тухай | Дугаар 207 | 132 |
| 96. | Вальтер Хайссигийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай | Дугаар 208 | 132 |
| 97. | Зарим шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай | Дугаар 209 | 132 |
| 98. | Ой тэмдэглэх тухай | Дугаар 02 | 133 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 99. | Журамд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 275 | 133 |
| 100. | Дүрэм батлах тухай | Дугаар 276 | 134 |
| 101. | Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 277 | 136 |
| 102. | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 1 | 141 |
| 103. | Ажилд томилох тухай | Дугаар 2 | 141 |
| 104. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай | Дугаар 3 | 141 |
| 105. | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож мөдүүлэх тухай | Дугаар 4 | 142 |
| 106. | Хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх тухай | Дугаар 5 | 142 |
| 107. | Зөөшөөрөл олгох тухай | Дугаар 6 | 142 |

| | | | |
|---|---|---|---|
| 108. | Согтууруулах ундааны үйлдвэрлэл, борлуулалтад тавих хяналтыг хүчтэй болгох тухай | Дугаар 7 | 143 |
| 109. | Монголын залуучуудын холбооны санаачилгыг дэмжих тухай | Дугаар 8 | 143 |
| 110. | "Төрийн мэдээлэл" эмхтгэлийг захиалж байх тухай | Дугаар 11 | 144 |
| 111. | Гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөн тогтоох тухай | Дугаар 12 | 144 |


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр** **Дугаар 199** **Улаанбаатар хот**

**Цэрэнгийн Дагданд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай**

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж хайлуур жоншны аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, экспортыг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн харьяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн захирлын эдийн засаг эрхэлсэн орлогч Цэрэнгийн Дагданд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр** **Дугаар 200** **Улаанбаатар хот**

**Чойгивын Сангидоржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Боловсрол, урлагийн байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, өсвөр, залуу үед хөгжмийн боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх, дуу, хөгжмийн олон шидэг бүтээл туурвиж, монголын орчин цагийн хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж хөгжмийн зохиолч Чойгивын Сангидоржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр** **Дугаар 201** **Улаанбаатар хот**

**Очирбатын Ичинхорлоод Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Урлаг, боловсролын байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж сонгодог болон үндэсний олон дуурь, жүжгийн дүрүүдийг чадварлаг бүтээж, дуулах урлагийг хөгжүүлэх, мэргэжлийн дуулаачдыг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Соёл урлагийн их сургуулийн багш Очирбатын Ичинхорлоод Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 202 | Улаанбаатар хот

**Хорлоогийн Далантайд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол ардын болон зохиолын дуунуудыг чадварлаг дуулж, драм, дуулалт жүжгийн дүрүүдийг амжилттай бүтээж, хөдөөгийн хөдөлмөрчдөд урлаг соёлоор үйлчлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн Театр, киноны хүрээлэнгийн гоцлол дуучин Хорлоогийн Далантайд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 203 | Улаанбаатар хот

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, соёл, урлаг, хууль хяналт, төрийн болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Банзрагчийн Бурмаа - Монгол Улсын их сургуулийн Физик элетроникийн сургуулийн багш

### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Гүнчингийн Алтангэрэл -Соёл урлагийн их сургуулийн тэргүүн дэд захирал
2. Бат-Өлзийн Баасан -Улсын мэргэжлийн хяналтын газрын үйлдвэрлэлийн салбар хариуцсан дэд дарга
3. Даваажавын Бадам -Нийслэлийн Баянгол дүүргийн татварын хэлтсийн тасгийн дарга
4. Нэршүүгийн Бадамханд - Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр дунд сургуулийн монгол хэл-уран зохиолын багш
5. Гуржавын Бадмаанямбуу -Улсын клиникийн 2 дугаар нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч, их эмч
6. Нэргүйн Батменх -Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа үйлчилгээний авто баазын жолооч
7. Дагвын Баттулга -Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Ард Улсад суугаа Элчин сайдын яамны 1 дүгээр нарийн бичгийн дарга
8. Жамсрангийн Батцэнгэл -Ховд аймгийн хөгжимт жүжгийн театрын гоцлол дуучин
9. Цэдэнгийн Баярбилэг -МОНЦАМЭ агентлагийн хэвлэх цехийн хэвлэгч
10. Шаравдоржийн Болд -П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн мэдрэлийн мэс засалч их эмч
11. Энгэлийн Буянтөр -"Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн ахлах инженер
12. Рэнцэнгийн Гангаалхам -Төрийн холбооны газрын "Их тэнгэр" цогцолбор дахь салбарын АТС-ын техникч
13. Оргодолын Дамба -Нийслэлийн "Эмийн үйлдвэр" ХК-ийн захирал
14. Баярмагнайн Дашзэвэг -Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын орлогч
15. Ягааны Дашзэвэг -Нийслэлийн эм хангамж нийлүүлэх "Амин шүүдэр" ХХК-ийн захирал
16. Дампилын Догоо -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн сургууль цэцэрлэгийн "Ирээдүй" цогцолбор 1 дүгээр сургуулийн сургалтын технологич
17. Дамаагийн Долгорсүрэн -Нийслэлийн Багануур дүүргийн Боловсрол цогцолборын зөвлөх багш
18. Санжийн -Увс аймгийн Мал

| | | | |
|---|---|---|---|
| Дэшин | эмнэлгийн лабораторийн их эмч | 34. Дагвын Санжаасүрэн | -Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч |
| 19. Ухнаагийн Ендон | -Айрагийн уулын үйлдвэрийн дарга | 35. Наваандоржийн Содномцог | -Монгол-Хятадын хоорондын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн хариуцлагатай нарийн бичгийн дарга |
| 20. Пунцагийн Жадамбаа | -"Монголросцветмет" нэгдлийн материал техникийн хангамжийн баазын жолооч | 36. Түдэвдоржийн Сүхээ | -Улсын клиникийн 2 дугаар нэгдсэн эмнэлгийн хүүхдийн хэсгийн эмч |
| 21. Намсрайн Жамъянсүрэн | -Нийслэлийн Налайх дүүргийн "Голомт" цогцолбор сургуулийн гүйцэтгэх захирал | 37. Бирваагийн Сэрвүүд | -Төмөр замын коллежийн захирал |
| 22. Чулуунбатын Жанчив | -Заамарын алтны үйлдвэрийн захирал | 38. Орихын Төмөрсанаа | -Увс аймгийн Шуудан холбооны албаны хэвлэл борлуулагч |
| 23. Галиндэвийн Зодов | -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 97 дугаар дунд сургуулийн монгол хэл-уран зохиолын багш | 39. Жамцын Түвшинжаргал | -Ховд аймгийн Булган сум дахь сум дундын прокурорын газрын ахлах прокурор |
| 24. Төмөр-Очирын Зориг | - Эмнэлгийн тусламжийг удирдах газрын эм зүйн албаны мэргэжилтэн | 40. Дамбийн Уртнасан | -Ховд аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн сувиллын яслийн эрхлэгч |
| 25. Лувсангомбын Идэрбат | -Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын хөгжимчин | 41. Пүрэвийн Цэнд | -Нийслэлийн эрүүл мэндийн "Хүмүүн Эрдэнэ" хувийн лабораторийн захирал |
| 26. Санжаагийн Лхаасүрэн | -Нийслэлийн Авто замын "Ялгуусан" ХХК-ийн дэд захирал | 42. Очирын Цэрэндулам | -Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтсийн дарга |
| 27. Дэмбэрэлийн Лхагважав | -Улсын мэргэжлийн хяналтын газрын Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч | 43. Жигдэгийн Цэцэгмаа | -Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын хөгжимчин |
| 28. Дамдинсүрэнгийн Мөнхжаргал | -Увс аймгийн Цагаанхайрхан сумын малчин | 44. Сэрээтэрийн Чимэд | -"Биокомбинат" /ТӨҮГ/-ын засварын цехийн лифтийн техникч |
| 29. Батхуягийн Ноост | -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 2 дугаар дунд сургуулийн сургалтын менежер | 45. Дамбын Шийтэр | -"Монголросцветмет" нэгдлийн мэргэжилтэн |
| 30. Цэдэн-Ишийн Отгон | -Дундговь аймгийн Сайнцагаан сумын "МНЧ" ХХК-ийн эмийн сангийн эм зүйч | 46. Дүүдэйн Энхжаргал | -Улсын мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч |
| 31. Аюушжавын Оюунбилэг | -Улсын клиникийн төв эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч | 47. Мижидийн Ягаан | -Орхон их сургуулийн проректор |
| 32. Дэмбэрэлийн Өлзийбаатар | -Үндэсний архивын газрын дарга | 48. Чойжамцын Янжинханд | -Дархан-Уул аймгийн Дархан сумын "Од" цогцолбор дунд сургуулийн бага анги хариуцсан хичээлийн эрхлэгч |
| 33. Дарийн Пунцаг | -Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Кызыл хотод суугаа ерөнхий консул | | |

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

| | | | |
|---|---|---|---|
| 1. Самдангийн Володя | -Төрийн холбооны газрын инженер, хошууч | 3. Жамбалын Мягмаржав | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн болон гамшгаас хамгаалах штабын офицер, хурандаа |
| 2. Шагдарын Жавзмаа | -Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын дуучин | 4. Шаравжамцын Нэргүй | -Төрийн холбооны газрын техникч |

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Доржпаламын Алагаа -Хөвсгөл аймгийн "Хөвсгөл геологи" ХК-ийн өрмийн мастер
2. Баяндоогийн Алгаа -Баян-Өлгий аймгийн Буянт сумын холбооны салбарын эрхлэгч
3. Дүүрэнбатын Алтангэрэл -Улсын Их Хурлын Тамгын газрын захиргаа, олон нийттэй харилцах хэлтсийн зохион байгуулагч
4. Данзанравжаагийн Алтансүх -Өргөний уулын үйлдвэрийн авто кранчин
5. Зэвын Алтанцэцэг -Нийслэлийн Монголэмимпекс концерний гэрээ хангамжийн мэргэжилтэн
6. Нацагдоржийн Амгалан -Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын гоцлол дуучин
7. Амгаабазарын Аюурзана -Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч
8. Сэрээжидийн Баажаа -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 21 дүгээр цэцэрлэгийн багш
9. Доржзоедын Баасанжав -Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн эрхлэгч, зөвлөх эмч
10. Ширчингийн Бадмаанямбуу -Нийслэлийн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ХК-ийн засварын инженер
11. Од-Осорын Банзрагч -"Монголросцветмет" нэгдлийн жолооч
12. Ангарагийн Батаа -Өргөний уулын үйлдвэрийн өрмийн машинч
13. Гомбосүрэнгийн Батбаяр -Нийслэлийн "Дулааны 3 дугаар цахилгаа станц" ХК-ийн гагнуурчин
14. Түмэндэмбэрэлийн Батбаяр -Нийслэлийн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ХК-ийн уурын хэсгийн дарга
15. Цэен-Ойдовын Батмөнх -Улсын Их Хурлын Тамгын газрын санхүү, үйлчилгээний хэлтсийн нярав
16. Товуучийн Батсуурь -Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын жолооч
17. Мишигийн Баянжаргал -Нийслэлийн Баянгол дүүргийн 95 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
18. Янжигийн Баянжаргал -Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн мэргэжилтэн
19. Баатарын Баярцэцэг -Гэмтэл согог сэргээн засах клиникийн эмнэлгийн эмийн сангийн эрхлэгч
20. Минсэлийн Болдбаатар -Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн захирлын 1 дүгээр орлогч
21. Мөнхийн Бүть -Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн төлөөлөгч
22. Дашлхүмбийн Галбаатар -Монгол улсын их сургуулийн Монгол хэл, соёлын сургуулийн утга зохиолын тэнхмийн багш
23. Суйдааны Гантогоо -Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч
24. Болзоогийн Даваахүү -Үндэсний статистикийн газрын ахлах мэргэжилтэн
25. Цэндийн Дагва-Очир -Төмөр замын коллежийн биеийн тамирын багш
26. Маамуугийн Дарамбазар -Увс аймгийн Өндөрхангай сумын дунд сургуулийн физикийн багш
27. Цэвэгдоогийн Дариймаа -Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
28. Дамдинсүрэнгийн Дашбаяр -Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч
29. Дамдинсүрэнгийн Дашдорж -"Монголросцветмет" нэгдлийн жолооч
30. Пэлхүүгийн Дашпунцаг - "Монголросцветмет нэгдлийн материал техник хангамжийн баазын нярав
31. Намсрайн Дашцэрэн -Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
32. Ядамсүрэнгийн Дуламханд -Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Засаг дарга
33. Дампилын Дэлгэрсайхан -Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга, зөвлөх эмч
34. Хандын Ендонпунцаг -Хөвсгөл аймгийн "Хөвсгөл геологи" ХК-ийн объектын ахлагч
35. Буяндэлгэрийн Жанлавцогзол -Дорнод аймгийн Аудитын газрын шинжээч
36. Жамсранжавын Жаргалсайхан -Дорноговь аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч
37. Санзайдожийн Ичиннороов -Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн ерөнхий инженерийн үйлдвэр эрхэлсэн орлогч
38. Магсарын Лувсандагва -Хөвсгөл аймгийн "Хөвгөл геологи" ХК-ийн техник геологич
39. Цэндийн Лхагвасүрэн -Дундговь аймгийн Хулд сумын эмийн сангийн эрхлэгч
40. Гүвээгийн Лхамжав -Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн
41. Ганжуурын Лхамцэрэн -Төв аймгийн Батсүмбэр сумын дунд сургуулийн бага ангийн багш
42. Бадамхүүгийн Молор -Нийслэлийн хөнгөн үйлдвэрлэлийн "Булигаар" ХК-ийн боловсруулах цехийн ажилчин
43. Натавын -Нийслэлийн Хан-Уул

Мягмар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн шүдний их эмч

44. Содномдаржаагийн Мягмарсүрэн -Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургуулийн физикийн тэнхмийн эрхлэгч

45. Дамдины Наранцэцэг -Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн эрхлэгч, их эмч

46. Дэнсмаагийн Наранцэцэг -Төв аймгийн Жаргалант сумын эмийн сангийн эрхлэгч

47. Жаргалын Нина -Нийслэлийн эм нийлүүлэлтийн "Монфармтрейд" ХХК-ийн захирал

48. Цэгмидийн Нина -Дорнод аймгийн Нэгдсэн эмнэлгийн дүн бүртгэгч, бага эмч

49. Сахъяагийн Нямаа -Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын мэргэжилтэн

50. Даваагийн Нямдаваа -Булган аймгийн усны аж ахуйн "Булган-Ундарга" ХК-ийн бригадын дарга

51. Намнангийн Нямжав -Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Элчин сайдын яамны зөвлөх

52. Шатарын Ойнбор -Дундговь аймгийн Луус сумын мал эмнэлэг, үржлийн албаны "Луус" ХХК-ийн захирал

53. Ануарбекийн Онай -Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Цагааннуур тосгоны цэцэрлэгийн эрхлэгч

54. Лхүмбийн Отгонцэцэг -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны Засаг дарга

55. Лувсанцэрэнгийн Оюун -Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

56. Тавхайн Оюунтунгалаг -Нийслэлийн Баянгол дүүргийн 51 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

57. Далхжавын Оюунчимэг -Улсын мэргэжлийн хяналтын газрын хэлтсийн дарга

58. Дамдинсүрэнгийн Оюунчимэг -Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургуулийн биологийн тэнхмийн багш

59. Шагдарын Өлзийбаяр -Хөвсгөл аймгийн "Хөвсгөл геологи" ХК-ийн гарааш ийн механик

60. Шагдаржавын Пүрэв -Өмнөговь аймгийн Ноён сум дахь сум дундын эмнэлгийн мэс заслын их эмч

61. Ярвааны Пүрэвжав -Нийслэлийн хөнгөн үйлдвэрлэлийн "Булигаар" ХК-ийн боловсруулах цехийн ажилчин

62. Дашцэрэнгийн Рэнцэннороов -Дархан-Уул аймгийн Дархан сумын "Од" цогцолбор дунд сургуулийн бага ангийн багш

63. Дамдины Салдат -Булган аймгийн усны аж ахуйн "Булган-Ус" ХХК-ийн засварын бригадын дарга

64. Чимэдийн Санжаасүрэн -Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын жолооч

65. Дарийн Сахъяа -Шинжлэх ухаан, техникийн их сургуулийн хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

66. Батсүхийн Саруул -Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч, зөвлөх эмч

67. Цэдэвсүрэнгийн Сугир -Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтан

68. Мягмарын Сэддорж -Хөвсгөл аймгийн "Хөвсгөл геологи" ХК-ийн дэд захирал

69. Рэндоогийн Таня -Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн хэт авиа оношлогооны эмч

70. Нямаагийн Төмөрхуяг -Улсын мэргэжлийн хяналтын газрын хилийн мэргэжлийн хяналтын албаны улсын ахлах байцаагч

71. Баянжаргалын Төртогтох -Нийслэлийн татварын газрын статистикийн хэлтсийн дарга

72. Юмсүрэнгийн Туул -Үндэсний статистикийн газрын ахлах мэргэжилтэн

73. Бадарчийн Тэрбиш -Нийслэлийн геологи уул уурхайн "Хүдэр-Эрдэнэ" ХХК-ийн экскаваторчин

74. Дуламжавын Улаанхүү -Айрагийн үйлдвэрийн жолооч

75. Базарсадын Уранчимэг -Эмнэлгийн тусламжийг удирдах газрын эмгэг судлаач, их эмч

76. Аубакирийн Ханат -Баян-Өлгий аймгийн Стандартчилал хэмжил зүйн төвийн дарга

77. Олзотын Хишгээ -Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч, эмч

78. Намжилсүрэнгийн Хүрэлбаатар -Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

79. Очирын Цогзолмаа -Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтын хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга, улсын ахлах байцаагч

80. Гүрбадамын Цэвэлсүрэн -Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн орчуулга судлалын тэнхмийн багш

81. Эрдэнэбатын Цэрэндорж -Хөвсгөл аймгийн "Хөвсгөл геологи" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч

82. Норовын Цэрэнханд -Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын хэлтсийн дарга

83. Дамдинжавын Цэцгээ -Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын халдвар судлагч их эмч

84. Хажиддоржийн Чонцалдулам -Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эмчилгээ, чанарын байцаагч

85. Жаргалын Чулуунбаатар -Нийслэлийн геологи, уул уурхайн "Хүдэр-Эрдэнэ" ХХК-ийн жолооч

86. Найдангийн Энхбаатар -Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн ахлах геологич

87. Сангидоржийн Энхжаргал -Монголросцветмет нэгдлийн барилгын удирдах газрын цахилгааны угсрагч, засварчин

88. Цэрэндашийн Энхцэцэг -Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын гоцлол хөгжимчин

89. Пунцаггарваагийн Эрдэнэ-Очир -Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн нэвтрэгч

90. Равдан-Очирын Эрдэнэчимэг -Нийслэлийн Авто замын "Эрдэнэ зам" ХК-ийн инженер

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Цоодолын Баатарсүрэн -Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын дуучин
2. Санжаагийн Бэрнасан -Төрийн холбооны газрын инженер, хошууч
3. Дашдондогийн Дамдинсүрэн -Дорнод аймгийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн ахлах байцаагч
4. Юндэнгийн Зохиолч -Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын зохион байгуулагч, менежер
5. Довдогийн Мягмарсүрэн -Төрийн холбооны газрын Орхон аймаг дахь салбарын инженер, хошууч
6. Түндэвцэрэнгийн Оюунчимэг -Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн их эмч
7. Батхуягийн Пүрэвсүрэн -Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын дуучин
8. Бямбаагийн Сүхбаатар -Дорнод аймгийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, дэд хурандаа
9. Чүлтэмсүрэнгийн Төмөрхуяг -Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэрэг, иргэний хамгаалалтын штабын офицер

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр** **Дугаар 204** **Улаанбаатар хот**

**Зарим хүнийг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Эр зориг, авхаалж самбаа гарган, голын усанд живсэн дөрвөн хүний амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар багийн иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч Андуугийн Цэцэнбилэг, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2 дугаар багийн иргэн, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн ажилчин Ойдовын Наранбат, мөн аймгийн Шаамар сумын 10 жилийн дунд сургуулийн 7-в ангийн сурагч Цэцэгмаагийн Батмөнх нарыг "Шударга журам" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр** **Дугаар 205** **Улаанбаатар хот**

**Зарим уяачдад улсын тод манлай уяач цол олгох тухай**

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн **ЗАРЛИГ БОЛГОХ** нь:

Монгол түмний цэнгэлийн манлай- Улсын баяр наадмын болон шигшмэл, бүсийн уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлгыг чамбай тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулж, наадамчи олноо баясгасан дор дурдсан хүмүүст улсын тод манлай уяач цол олгосугай.

1. Данзаннямын Даваахүү -Төв аймгийн Баянцагаан сумын харъяат, уяач
2. Дамбадаржаагийн Онон -Төв аймгийн Сэргэлэн сумын харъяат, уяач
3. Цэрэндоржийн Аюуш -Архангай аймгийн Хотонт сумын харъяат, уяач

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

**Зарим уяачдад улсын манлай уяач цол олгох тухай**

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн **ЗАРЛИГ БОЛГОХ** нь:

Улсын их баяр наадам, шигшмэл болон бусийн хурдан морины уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлгыг чамбай тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулж, уяачийн эрдэм, чадварыг харуулсан дор дурдсан хүмүүст улсын манлай уяач цол олгосугай.

1. Дагвадоржийн Ганбаатар -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн харьяат, уяач
2. Аюушийн Ухна -Сүхбаатар аймгийн Халзан сумын харьяат, уяач
3. Сумьяасүрэнгийн Ганхуяг -Төв аймгийн Баянцогт сумын харьяат, уяач
4. Ноостын Түмэнбаяр -Нийслэлийн Налайх дүүргийн харьяат, уяач

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

**Зарим уяачдад улсын алдарт уяач цол олгох тухай**

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн **ЗАРЛИГ БОЛГОХ** нь:

Улсын их баяр наадам, шигшмэл болон бусийн уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлгыг чамбай тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулж, өндөр амжилт гаргасан дор дурдсан хүмүүст улсын алдарт уяач цол олгосугай.

1. Дагвадоржийн Цэрэнжигмэд -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн харьяат, уяач
2. Дэмчигжавын Адъяабазар -Төв аймгийн Батсүмбэр сумын харьяат, уяач
3. Бэгзсүрэнгийн Содномцог -Завхан аймгийн Цэцэн-Уул сумын харьяат, уяач
4. Галсандагвын Нямдаваа -Ховд аймгийн Чандмань сумын харьяат, уяач
5. Намсрайн Мөнхдаш -Дархан-Уул аймгийн харьяат, уяач
6. Энэбишийн Ганбат -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн харьяат, уяач
7. Баасангийн Цэдэв -Баянхонгор аймгийн Бууцагаан сумын харьяат, уяач
8. Гончигжавын Алтангэрэл -Дорноговь аймгийн Сайншанд сумын харьяат, уяач
9. Дашцэрэнгийн Одгэрэл -Төв аймгийн Баянцогт сумын харьяат, уяач
10. Батхүрэлийн Бат-Өлзий -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн харьяат, уяач

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

**Вальтер Хайссигийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай**

Монгол Улсыг гадаадад сурталчлах, монгол судлалыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ХБНГУ-ын иргэн, монголч эрдэмтэн Вальтер Хайссигийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

**Зарим шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн **ЗАРЛИГ БОЛГОХ** нь:

Ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд шүүгчийн албан тушаалд

тэнцэхгүй тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул Гаашидын Дэлгэрбямбыг Баянхонгор аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Совдын Мөнхбаярыг Завхан аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн; Содномсамбуугийн Цэрмааг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн; Ванчингийн Дэлгэрмөрөнг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн; Баянтөгсийн Намхайдоржийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн; Лхагвын Нинжбат, Балжиннямын Оюун, Лувсаншаравын Сарангуа нарыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Ой тэмдэглэх тухай

Монголын төр ёс хууль цаазын сэтгэлгээний түүхийн нэн содон онцгой тэмдэглэлт үйл хэргийн нэг бол 1924 онд Улсын анхдугаар Их Хурал чуулан хуралдаж, анхны Үндсэн хуулийг зүйл бүрээр нь хэлэлцэн баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласан түүхэн үйл явдал билээ.

Энэ нь монголын ард түмний 1911 оны үндэсний хувьсгал, 1921 оны ардын хувьсгалын үр дүнг баталгаажуулж, ард нийтээрээ сонгон байгуулдаг Бүгд Найрамдах төрийн цоо шинэ хэлбэрийг сонгож, Үндсэн хуульт байгууллыг тогтоон ард иргэний эрх чөлөөг хуульчлан хамгаалж, улс төр, эдийн засаг, эрдэм соёл юугаа дэлхийн жишиг, нийтийн байдлын шинэ есонд дэвшүүлэх үндсийг тавьсан олон талын гүн утга агуулга, учир холбогдлоороо үндэсний ой санамжаас үл мартагдах, эрх чөлөөт иргэн бүрийн бахархан дурсах түүх болон үлдсэн байна.

Анхны Үндсэн хуулийн үзэл санаа, суурь зарчим дараа дараачийн Үндсэн хуулинд шингэн уламжлагдаж, ардын Бүгд Найрамдах төрийн байгуулал улам бүр ардчилсан, эрх зүйт төрийн хэв шинжээр төлөвшин батжиж шинэ зууны Монгол улсын хөгжил дэвшлийн хөтөч болж байна.

Олон бүгдээр нэгэн сэтгэл, нийтийн хүчээр хичээн зүтгэж улс төр үндэс язгуураа үүрд батлан хамгаалах чухал зорилгыг агуулсан тэрхүү түүхт явдлын тэгш ойг онцгойлон тэмдэглэх нь ард түмэн эрхэм зорилгоо хэрэгжүүлэх, тэдэнд эх орончоо үндэсний үзлийг төлөвшүүлэх, Үндсэн хуулийн үнэт зүйлсээ бататган бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой тул Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэгийн 3 дахь заалтыг үндэслэн **ЗАРЛИГ** буулгах нь:

1. Анхдугаар Үндсэн хуулийг баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны 80 жилийн ойг 2004 онд монголын ард түмний үндэсний бахархал, төрт ёсны баяр болгон ёслон тэмдэглэсүгэй.

2. Энэ түүхт ойг угтаж Үндсэн хуульт төрийн байгуулал, хууль ёсыг бэхжүүлэх, улс орны эдийн засаг, иргэдийн аюулгүй байдлыг улам бүр баталгаажуулах, олон нийтийн үндэсний болон түүхийн ухамсар, иргэний бахархлыг бадраах, Үндсэн хуулийн судлал шинжилгээ, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, иргэдийн эрх зүйн сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр эрчимтэй ажил зохиож, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллахыг Засгийн газар /Ерөнхий сайд Н. Энхбаяр/-т чиглэл болгосугай.

3. Тусгаар тогтносон, бүрэн эрхт Бүгд Найрамдах Монгол улсын иргэн гэсэн бахархам омогшлоор хүн бүр сэтгэл зүрхээ хөглөж, бүтээж туурвих, эв зэийг сахиж улс орноо хөгжүүлэхийн төлөө идэвхийлэн ажиллахыг нийт иргэддээ уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ НАЦАГИЙН БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД НАМБАРЫН ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 275

Улаанбаатар хот

### Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Олимпийн наадамд бэлтгэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 187 дугаар тогтоолоор баталсан "Мөнгөн шагнал олгох журам"-ын 5 дугаар заалтын "... шагнал олгуулахаар биеийн тамир, спортын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд өргөн барина" гэснийг "... холбогдох

материалыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Шагнал олгох шийдвэрийг биеийн тамир, спортын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар гаргана" гэж өөрчлөн найруулсугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Эрүүл мэндийн
сайд П.НЯМДАВАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

### Дүрэм батлах тухай

Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм"-ийг хавсралт ёсоор батлсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм, журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 240 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Боловсрол, соёл, шинжлэх
ухааны сайд А.ЦАНЖИД

*Засгийн газрын 2003 оны 276 дугаар тогтоолын хавсралт*

## БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг зүйл

1.1. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага нь дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны түвшин, сургалтын хөтөлбөр, стандартын хэрэгжилтийн чанарт хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ хийж сургалт эрхлэх шаардлагыг хангаж байгаа талаар дүгнэлт гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.2. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага нь хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж дээд болон мэргэжлийн сургалтын байгууллагуудад сургалт-арга зүйн туслалцаа үзүүлж, магадлан итгэмжлэх чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий боловсролын байгууллага байна.

1.3. Магадлан итгэмжлэх байгууллага нь үйл ажиллагаандаа сургалтын байгууллага, тэдгээрийн нэгжийн бие даасан байдлыг хүндэтгэх, байгууллага болон хөтөлбөрүүдэд жигд шаардлага тавих, аливаа асуудлыг бусдын нөлөөнд үл автан олонхийн саналаар шийдвэрлэх зарчмыг баримтлан ажиллана.

1.4. Магадлан итгэмжлэл хийлгэх тухай хүсэлт гаргасан сургалтын байгууллага магадлан итгэмжлэх байгууллагатай гэрээ байгуулан холбогдох үйлчилгээний төлбөрийг төлнө. Төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.5. Гэрээнд өөрөөр заагаагүй бол буруу дүгнэлт гаргасны улмаас учирсан хохирлыг Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага бүрэн хариуцна.

1.6. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод байна. Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага болон хөтөлбөрийг Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагаас нийтэд мэдээлж байна.

1.7. Магадлан итгэмжлэлийг сайн дурын үндсэн дээр явуулна. Төрийн захиргааны төв байгууллага болон ажил мэргэжлийн холбоод тодорхой хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийлгэх хүсэлт гаргавал Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага түүнийг хүлээн авч зохих журмын дагуу магадлан итгэмжлэл хийнэ.

1.8. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ өгч дүгнэлт гаргах үүрэг бүхий төрөлжсөн мэргэжлийн зөвлөлүүдийг Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага дэргэдээ байгуулан ажиллуулж болно. Тодорхой хөтөлбөрийг магадлан итгэмжлэхдээ Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага төрөлжсөн мэргэжлийн зөвлөлийн санал дүгнэлийг үндэслэн эцсийн шийдвэрийг гаргана.

1.9. Сургалтын байгууллагыг магадлан итгэмжилсэн шийдвэрийн хүчин төгөлдөр байх хугацаа эхний удаад 5 жил, дараагийн удаад 10 жил байна. Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх хугацааг мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагаас 5-6 жилээр тогтооно.

1.10. Сургалтын байгууллага татан буугдсан, магадлан итгэмжлэгдсэн байгууллагын бүрэлдэхүүнээс гарч бие даан өөрчлөн байгуулагдсан, сургалтын хөтөлбөрийн чиглэл нь өөрчлөгдсөн, магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан тохиолдолд тухайн байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжилснийг гэрчлэх баримт бичиг хүчингүй болно. Магадлан итгэмжлэгдсэн болон итгэмжлэгдээгүй сургалтын хэд хэдэн байгууллага нэгдсэн тохиолдолд магадлан итгэмжлэл хүчинтэй байна.

### Хоёр. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх

2.1. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага шинжээчдэд тавих шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг тогтооно.

2.2. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагад эрх олгож улсын бүртгэлд бүртгэнэ.

2.3. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын саналыг үндэслэн тус байгууллагад ажиллах шинжээчдэд эрх олгоно.

2.4. Боловсролын болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрэм, холбогдох шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг зөрчсөн Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага, шинжээчдийн эрхийг хугацаанаас нь өмнө зогсоож болно.

### Гурав. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын бүрэн эрх

3.1. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар Монгол Улсын боловсролын чанарыг дээшлүүлж, олон улсын нийтлэг жишигт хүргэхэд хувь нэмэр оруулах;

б/сургалтын байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу тэдгээрт үйл ажиллагаатай нь холбоотой зөвлөгөө өгөх;

в/магадлан итгэмжлэлийн урьдчилсан шаардлага, шалгуур үзүүлэлтүүд, өөрийн үнэлгээ хийх чиглэлийг тогтоож өөрийн үнэлгээний тайланд тавих нийтлэг шаардлагыг тодорхойлох;

г/магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулах, шинжээчдийг мэргэшүүлэх, нийтэд мэдээлэл өгөх, ном, товхимол хэвлүүлэх;

д/магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага болон сургалтын хөтөлбөрийн нэгдсэн бүртгэл хөтлөх, улсын хэмжээний сан бүрдүүлэх, тайлан мэдээ гаргах, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах, бүтээгдэхүүн нийлүүлэх;

е/ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг гадаад орон болон олон улсын байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллах, магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд гадаад орны мэргэшлийн шинжээчдийг оролцуулах.

3.2. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага дор дурдсан эрх эдэлнэ:

а/Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиуд болон энэхүү дүрэмд нийцүүлэн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэн явуулах;

б/магадлан итгэмжлүүлэхээр ирүүлсэн материалтай танилцаж, шаардлага хангаагүй тохиолдолд зохих үндэслэлээр буцаах;

в/ магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангах;

г/магадлан итгэмжлэлийн холбогдолтой баримт бичгийн загварыг батлах;

д/сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэгдсэнийг баталгаажуулан "Гэрчилгээ" олгох;

е/хууль тогтоомжид заасан бусад эрх.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

### Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам батлах тухай" Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 161 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1. Журмын 3.4-т дор дурдсан заалтуудыг нэмэх:

"Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 /0-20.0/ хувийн биелэлттэй байна гэж үнэ"

"Ямар ч ажил зохион байгуулаагүй бол 0 үнэлгээ өгнө"

2. Журмын 2.5.2-ыг "УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөр Засгийн газарт өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн" гэж, 2.5.3-ыг "Сайд, аймаг, нийслэлийн Засаг даргаас яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт" гэж, 2.5.4-ийг "Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/ нараас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт" гэж, 2.6.5-ыг "Аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт /зорилт нэг бүрээр/" гэж, 2.7.2-ыг "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын болон аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын хөтөлбөрүүд, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн тухайн онд хүрсэн түвшин нь тодорхой тоо, хувиар илэрхийлэгдсэн байна" гэж, 2.9-ийг "Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтийн үнэлгээг үр дүнгийн гэрээ байгуулсан төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/ бүр өгнө" гэж, 3.1-ийг "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын үндэсний хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт нэг бүрийн гүйцэтгэлийг өссөн дүнгээр гаргаж, тухайн зорилтын шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн дундаж оноогоор дүгнэнэ" гэж, 3.2-ыг "Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/-аас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ болон төсвийн ерөнхийлөн захирагч нарын ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг худалдан авах болон нийлүүлэх бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг хүрэх түвшинд харьцуулан хувиар илэрхийлж дундаж оноогоор дүгнэнэ" гэж, 3.4-ийн "Бэлтгэл ажил бүрэн хийгдсэн, тодорхой хэмжээнд ажил эхэлсэн бол 37.5 хувь /25.0-50.0 хувь/" гэсэн заалтыг "Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж буй ажлын түвшинг харгалзан 50.0 хувь" гэж, 3.4-ийн "Тухайн заалтад тусгагдсан асуудал боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж буй ажлын түвшинг харгалзан 12.5 хувь /10-25.0 хувь/-ийн биелэлттэй байна" гэсэн заалтыг "Тухайн заалтад тусгагдсан асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж буй ажлын түвшинг харгалзан 30 хувь" гэж тус тус өөрчлөн найруулсугай.

3. Журмын 2.2-т "... тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор" гэснийг "... тайланг дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор" гэж, 2.5-ын "Үйл ажиллагааны тайлан" гэснийг "Үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан" гэж, 2.6-гийн "Үйл ажиллагааны тайлан нь дараах хавсралтаас бүрдэнэ" гэснийг "Тайлан нь дараах хавсралтаас бүрдэнэ" гэж, 2.6.4-ийн "/арга хэмжээ нэг бүрээр/" гэснийг "/зорилт нэг бүрээр/" гэж, 3.3-ын "Т-төлөвлөгөө буюу өмнөх оны гүйцэтгэл" гэснийг "З-зорилт буюу хүрэх түвшин" гэж, 3.4-ийн 1 дэх заалтын "... үр дүн гарсан бол 100 хувь" гэснийг "... үр дүн гарч, тогтворжсон бол 100 хувь" гэж, 3.4-ийн 2 дахь заалтын "... үр дүн нь зарим хэмжээгээр гарч

эхэлж байгаа бол 87.5 хувь" гэснийг "... гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь" гэж, 3.4-ийн 3 дахь заалтын "62.5 хувь" гэснийг "70.0 хувь" гэж тус тус өөрчилсүгэй.

4. Журмын 2.5.5, 2.6.7, 2.7.3, 2.10, 2.12 болон "Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг тооцох аргачлал"-ыг баталсан 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ"-г хавсралт ёсоор өөрчлөн найруулсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд — Н.ЭНХБАЯР**

**Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга — Ө.ЭНХТҮВШИН**

*Засгийн газрын 2003 оны 277 дугаар тогтоолын хавсралт*

## ЯАМ БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

**Нэг.** Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, зорилт

1.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь төрийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаархи мэдээлэлд боловсруулалт хийж, зорилтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг, нөлөөллийг шинжлэн дүгнэх, хөгжлийн дараагийн зорилтыг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл, санал дүгнэлт, зөвлөмжөөр хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа юм.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн зорилго нь төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүн, зардал, үр нөлөөллийг бодитойгоор тогтоох, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг баталгаажуулах, амжилтыг ахиулах, удирдлагыг цаг үеэ олсон, үнэн зөв мэдээллээр хангахад оршино.

1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь:

1.3.1. Үйл ажиллагааны тодорхойгүй байдлыг багасгах, гүйцэтгэлийг сайжруулах боломж, нөөцийг илрүүлж ашиглах;

1.3.2. Бодлогын сонголтыг хэрэгжүүлэх нөөцийн /орцын/ удирдлага, зохицуулалтын үр нөлөө, өгөөж, гарцыг сайжруулах;

1.3.3. Шийдвэр гаргах үйл ажиллагаар бодлогын хувилбар, санал дүгнэлт, зөвлөмжөөр дэмжихэд чиглэгдэнэ.

**Хоёр.** Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ, тавигдах шаардлага, тайлагнах хугацаа

2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага хамрагдана.

2.2. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь жилийн үйл ажиллагааны үр дүндээ хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.

2.3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жилд 6-гаас доошгүй яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд энэхүү журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

2.4. Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, түүнчлэн сум, дүүргийн үйл ажиллагааны явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.5. Үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан нь дараахь бүтэцтэй байна:

2.5.1. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн;

2.5.2. УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжээр Засгийн газарт өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн;

2.5.3. Сайд, аймаг, нийслэлийн Засаг даргаас яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт;

2.5.4. Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/ нараас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт;

2.5.5. Байгууллагын нээлттэй байдлыг хангах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн.

2.6. Тайлан нь дараахь хавсралтаас бүрдэнэ:

2.6.1. "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлт /шууд холбогдох арга хэмжээ нэг бүрээр/;

2.6.2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт /шууд холбогдох арга хэмжээ нэг бүрээр/;

2.6.3. Засаг даргаас Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт /заалт нэг бүрээр/;

2.6.4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт /зорилт нэг бүрээр/;

2.6.5. Аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт /зорилт нэг бүрээр/;

2.6.6. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ /энэ журмын хавсралт/.

2.7. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан нь дараахь шаардлагыг хангасан байна:

2.7.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ашигласан мэдээ, баримт нь үнэн зөв байна /ашигласан мэдээ, баримт нь үнэн зөв эсэх талаар мэдээлэл өгсөн албан тушаалтан хариуцлага хүлээнэ/;

2.7.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын болон аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын хөтөлбөрүүд, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн тухайн онд хүрсэн түвшин нь тодорхой тоо, хувиар илэрхийлэгдсэн байна.

2.8. Үр дүнгийн хяналт-шинжилгээг гүйцэтгэлийн бодит үр дүнг төлөвлөсөн зорилттой харьцуулж өсөлт, бууралтыг тооцоолох аргаар хийж, зорилт гүйцэтгэлийн зөрүүгийн шалтгааныг илрүүлэх, тасалдлыг нөхөх, илүү өндөр түвшний зорилго дэвшүүлэх боломж, нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр үнэлгээг гаргана.

2.9. Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтийн үнэлгээг үр дүнгийн гэрээ байгуулсан төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/ бүр гаргана.

2.10. Хяналт-шинжилгээний дүгнэлт, санал, зөвлөмж нь үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, тасалдал, доголдлын шалтгааныг илрүүлж засах, байгууллагын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, төсвийг оновчтой зарцуулах шийдвэр гаргах үндэслэл болно.

**Гурав.** Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

3.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын үндэсний хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт нэг бүрийн гүйцэтгэлийг өссөн дүнгээр гаргаж, тухайн зорилтын шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн дундаж оноогоор дүгнэнэ.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/-аас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай болон төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг хуудаслан авах болон нийлүүлэх бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг гүйцэтгэлтэй харьцуулан хувиар илэрхийлж дундаж оноогоор дүгнэнэ.

3.3. Зорилтын биелэлтийг дор дурдсан томъёогоор дүгнэнэ:

ЗБ = Г/Т. Энэ үнэлгээг хувиар илэрхийлэх бол ЗБ=Г/Тх100 гэж тооцно.

Энд ЗБ- зорилтын биелэлт

Г – гүйцэтгэл

Т – зорилт буюу хүрэх түвшин

Зорилтын биелэлтийн оноог Б=(Г/Т*100)*0.05 - томьёогоор тодорхойлно. Уг оноог үнэлгээний коэффциентээр үржүүлж үнэлгээний оноог тодорхойлно.

3.4. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй бодлогын зорилт, арга хэмжээний үнэлгээний оноог тухайн зорилт, арга хэмжээний биелэлтийн хувийг 0.05-аар үржүүлж тодорхойлно. Биелэлтийн хувийг тодорхойлохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр, үр дүн гарч, тогтворжсон бол 100 хувь;

- Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

- Тухайн заалтаар тавьсан зорилгодоо хүрэхийн тулд өөрсдөөс хамаарах бүх шийдвэрийг гаргаж, санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдсэн, шийдвэр гаргагч дээд байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь;

- Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь;

- Тухайн заалтад тусгагдсан асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь;

- Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувийн биелэлттэй байна гэж үзнэ.

- Ямарч ажил зохион байгуулаагүй бол 0 үнэлгээ өгнө.

3.5. Ерөнхий сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан батламжийн биелэлт нь зорилт нэг бүрийн биелэлтийн хувь /3.3-т заасан томъёогоор тодорхойлогдох/-ийг 0.05-аар үржүүлж гаргасан үнэлгээний онооны нийлбэрийн дунджаар илэрхийлэгдэнэ.

3.6. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг энэ журмын хавсралтаар баталсан «Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ»-ний дагуу хийнэ.

3.7. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ нь «Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ» гэсэн журмын хавсралтын үнэлгээний онооны нийлбэрийг үзүүлэлтийн тоонд хувааж гаргасан оноогоор илэрхийлэгдэнэ.

**Дөрөв.** Шагнал, урамшуулал

4.1. Ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан 3 яамны Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн 5 Засаг даргыг нэг сарын цалинтай тэнцэх мөнгөн шагналаар, авсан онооны дараалын дагуу 3 яам, 5 аймгийн Засаг даргын Тамгын газрыг дараахь шагналаар шагнаж урамшуулна. Үүнд:

1 дүгээр байр. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 3.0 сая төгрөгөөр;

2 дугаар байр. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 2.5 сая төгрөгөөр;

3 дугаар байр. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 2.0 сая төгрөгөөр;

4 дүгээр байр. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 1.5 сая төгрөгөөр;

5 дугаар байр. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 1.0 сая төгрөгөөр.

4.2.Шагналд зарцуулах хөрөнгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт жил бүр тусгана.

***Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад хяналт- шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмын хавсралт***

## ЯАМ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

| № | Шалгуур үзүүлэлтүүд | | Яам, аймаг, нийслэлээр | Хэмжих нэгж | Гүйцэтгэлийн хувь | Оноо | Үнэлгээний коэффицент | Үнэлгээний оноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I. Сайд, Засаг дарга нарын бодлогын зорилтын хэрэгжилтийн үнэлгээ | | | | | | | |
| 1. | Засгийн газрын бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн | 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн | яам | хувь | | | 1.4 | |
| | | | аймаг, нийслэл | | | | 1.2 | |
| | | 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт | яам | хувь | | | 1.0 | |
| | | 3. Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүн | яам, аймаг, нийслэл | хувь | | | 0.8 | |
| 2. | Аймаг, нийслэлийн бодлогын зорилтын хэрэгжилтийн явц үр дүн | 1. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн | аймаг, нийслэл. | хувь | | | 1.0 | |
| | | 2. Аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт | аймаг , нийслэл | хувь | | | 1.0 | |
| 3. | Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүн | 1. УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөр Засгийн газарт өгөгдсөн үүрэг, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийн явц | яам | хувь | | | 0.8 | |
| | | 2. Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүн | яам, аймаг, нийслэл | хувь | | | 1.0 | |
| | | 3. Аймаг, нийслэлийн Засаг даргаас Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт | аймаг, нийслэл | хувь | | | 1.0 | |
| | | 4.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/-аас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт | аймаг, нийслэл | хувь | | | 1.0 | |
| | II. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ | | | | | | | |
| 1. | 1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт | | яам | хувь | | | 1.3 | |
| | | | аймаг, нийслэл | хувь | | | 1.2 | |
| 2 | Байгууллагын нээлттэй байдал | 1.Санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт | яам | хувь | | | 0.9 | |
| | | | аймаг, нийслэл | хувь | | | 0.9 | |
| | | 2.ВЭБ сайтад тавьсан хууль тогтоомж, хөтөлбөр, бусад шийдвэрийн төсөл | яам | хувь | | | 0.9 | |
| | | 3.ВЭБ сайтад тавьсан мэдээлэлд иргэдээс ирсэн саналд өгсөн хариу, шийдвэрлэсэн байдал | яам | хувь | | | 0.9 | |
| | | 4. Засаг даргын захирамж, бусад шийдвэрийн төсөлд иргэдийн саналыг тусгасан байдал | аймаг, нийслэл | хувь | | | 0.9 | |
| | Ерөнхий үнэлгээ | | Оноо | - | - | - | - | |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

### Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

"Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд "Засгийн газрын тохируулагч агентлаг" гэсэн хэсэгт "3. Гамшгаас хамгаалах ерөнхий газар" гэж нэмж, мөн хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх ажлын хүрээнд "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсгийн "11.Гал түймэртэй тэмцэх газар", "32.Улсын нөөцийн газар" гэснийг, Батлан хамгаалахын сайдын эрхлэх ажлын хүрээнд "Засгийн газрын тохируулагч агентлаг" гэсэн хэсгийн "7.Иргэний хамгаалалтын газар" гэснийг тус тус хассугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.ЭНХТҮВШИН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

### Ажилд томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Пүрэвийн Дашийг Засгийн газрын тохируулагч агентлаг-Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргаар 6 сар хүртэл хугацаагаар түр томилсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.ЭНХТҮВШИН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

### Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2004 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 32000 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 20000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа 22601-31999 төгрөгийн бүрэн тэтгэвэр болон 15001-18000 төгрөгийн хувь тэнцүүлсэн тэтгэврийг 25 хувиар, 32000-аас дээшхи төгрөгийн бүрэн тэтгэвэр болон 18001-ээс дээшхи төгрөгийн хувь тэнцүүлсэн тэтгэврийг 15 хувиар нэмэгдүүлж 2004 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс тооцон олгох арга хэмжээ авахыг Сангийн, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 193 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Сангийн, эдийн засгийн сайд Ч.УЛААН

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.БАТБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр** **Дугаар 4** **Улаанбаатар хот**

**Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож мөрдүүлэх тухай**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2004 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн цагт 236 төгрөг 68 мөнгө буюу сард 40000 (дөчин мянган) төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 263 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд** **Ш.БАТБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр** **Дугаар 5** **Улаанбаатар хот**

**Хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх тухай**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн сангаас олгох хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж 2004 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн тооцон олгох арга хэмжээ авахыг Сангхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 194 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Санхүү, эдийн засгийн сайд** **Ч.УЛААН**

**Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд** **Ш.БАТБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр** **Дугаар 6** **Улаанбаатар хот**

**Зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгахтай холбоотой асуудлаар хууль тогтоомжид зохих зохицуулалт хийх хүртэл мэргэжлийн хяналтын байгууллагын чиглэлээр захиргааны журмаар хураасан эд зүйлийг улсын орлого болгох, устгах талаар шийдвэр гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дэргэдээ байгуулан ажиллуулж, үйл ажиллагаандаа Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолоор баталсан "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах журам"-ыг дагаж мөрдөхийг Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батбаатарт даалгасугай.

2. Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах журмыг хуульчлан зохицуулах талаар санал боловсруулж Засгийн газарт оруулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга** **Ө.ЭНХТҮВШИН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 7

Улаанбаатар хот

**Согтууруулах ундааны үйлдвэрлэл, борлуулатад тавих хяналтыг хүчтэй болгох тухай**

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Онцгой албан татварын тухай болон Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Архи, Спирт, Согтууруулах ундааны үйлдвэрүүдийг 2004 оны I улиралд багтаан аттестатчилж, хууль тогтоомжид заасан шаардлагад тэнцээгүй үйлдвэрүүдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д. Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаан нарт даалгасугай.

2. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д. Насанжаргал, үйлдвэр, худалдааны сайд Ч. Ганзориг, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д. Батбаатар нарт даалгах нь:

а/ согтууруулах ундааны үйлдвэрүүдийн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний баталгаажилт, технологийн бүртгэл хөтлөлт, лабораторийн үйл ажиллагаанд тавих хяналтыг эрс сайжруулах, архи, спиртийн үйлдвэрүүдийн технологийн заавры түүхий эдийн онцлогоос хамааруулан 2004 оны 1 дүгээр сард багтаан хянаж шинэчлэн батлуулж мөрдүүлсүгэй;

б/ төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын албадын болон хүнсний үйлдвэрүүдийн лабораториудад шаардагдах урвалж бодис, багаж хэрэгсэл нийлүүлэх арга хэмжээ авсугай;

в/ спирт үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийн туршилтын хугацаанд үйлдвэрлэсэн спиртийн хэмжээ, чанар, ашиглалт, үгсралтад нь хяналт тавин илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Санхүү, эдийн засгийн сайд **Ч.УЛААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар хот

**Монголын залуучуудын холбооны санаачилгыг дэмжих тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Арван зургаан нас хүрч Монгол Улсын иргэний үнэмлэх анх авч байгаа залуучуудаар Монгол Улсын иргэний андгай өргүүлж байх талаар Монголын залуучуудын холбооны гаргасан санаачилгыг дэмжсүгэй.

2. Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолын ажиллагааг Монголын залуучуудын холбоотой хамтран зохион байгуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд **А.ЦАНЖИД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр** | **Дугаар 11** | **Улаанбаатар хот**

**"Төрийн мэдээлэл" эмхтгэлийг захиалж байх тухай**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5, 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Баг, хороодоос нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, иргэдэд төрийн хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах зэрэг хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зорилгоор "Төрийн мэдээлэл" эмхтгэлийг баг, хороодын Засаг дарга нарын албан хэрэгцээнд зориулан улирал бүр захиалахад шаардагдах хөрөнгийг төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Эрхэлсэн ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд албан хэрэгцээний зориулалтаар хүлээн авсан "Төрийн мэдээлэл" эмхтгэл болон бусад хууль тогтоомжийг холбогдох ажилтанд хүлээлгэн өгч байхыг баг, хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Хууль зүй, дотоод хэргийн сайд** **Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр** | **Дугаар 12** | **Улаанбаатар хот**

**Гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөн тогтоох тухай**

Гаалийн тарифын тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газарт эрх олгох тухай 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хилийн Сүхбаатар, Алтанбулаг, Эрээнцав, Замын-Үүд, Цагааннуур, Ярант, Боршоо боомтоор 2004 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд импортлох хүнсний буудай, үрийн буудай, 2004 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хилийн бүх боомтоор импортлох гурилын гаалийн тарифын хувь хэмжээг "О" байхаар тус тус өөрчлөн тогтоосугай.

2. Гурил, гурилан бүтээгдэхүүний хангамж, үнийн тогтвортой байдлыг хангах асуудалд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Хүнс, хөдөө аж ахуйн сайд** **Д.НАСАНЖАРГАЛ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 325487
Хэвлэлийн хуудас 2.5